*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Ш.ШИНЭЧИМЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ Хариуцсан хяналтын чиглэлээр хяналт шалгалтын бодлого, төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх”** | | | | | | | |
| 1. | Салбарын хяналтын газарт дунд болон их эрсдэлтэй объектыг судалгаар хүргүүлж төлөвлөгөөт хяналт шалгалт хийх объектыг батлуулах | Батлагдсан төлөвлөгөөний тоо | 1 | 1 | 2024 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг үндэслэн их, дунд эрсдэлтэй объектын судалгаар гарган Shilenkhyanalt.gov.mn олон нийтийн порталаар дамжуулан салбарын хяналтын газарт хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.01 | 100% |
| **Зорилт 2. “ Байгаль орчны хяналтын чиглэлээр эрсдэлийг тодорхойлох, хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх”** | | | | | | | |
| 1. | Засгийг газрын 420 тогтоолоор батлагдсан байгаль орчны хяналтын чиглэлээр 15 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо | 2023 онд 37 объектыг шалгаж | 7 | 2024 оны 04 дүгээр сарын 25-с 10 сарын 30-ны хооронд 01/10 тоот удирдамжийн хүрээнд 16 ААНБ-д төлөвлөгөөт шалгалтыг хийж 01.1.4 кодтой хяналтын хуудсаар эрсдэлийн түвшинг үнэлэхэд 50.8%, хууль сахин мөрдөлт 41.5%-тай дунд эрсдэлтэй үнэлэгдэж 7 ААНБ-д 9.7 сая төгрөгний торгууль, 156 мянган төгрөгийн нөхөн төлбөр оногдуулж | 2024.03.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин, | Хууль сахин мөрдөлт- | 50 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 47,4% | | нийт 132 зөрчил илрүүлж 108 заалттай 14 албан шаардлагыг 14 аж ахуйн нэгжид хүргүүлж албан шаардлага 80 хувийн хэрэгжилттэй байна. | | |
| | | Зөрчил, арилгуулалтын % | Зөрчил арилгуулалт-82% | 100 | | | |
| 2. | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын ус, рашаан ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо | 0 | 30 | Иргэн аж ахуйн нэгжийн ус, рашаан ашиглалтад 30 ААНБ, 7 иргэнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. 29.2 сая төгрөгийн торгууль, 138.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг ногдуулж 1 аан-д 6 заалттай албан даалгавар, 4 аан-д 10 заалттай албан шаардлага хүргүүлж, албан шаардлага 80 хувийн хэрэгжилттэй байна. | 2024.03.01 2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин | 0 | 80 | | | |
| 3 | Усны сан бүхий газар, хүн амын ундны усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 30 | Усны сан бүхий газар, хүн амын ундны усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд аймгийн төвийг усаар хангагч ОНӨААТҮГ, ундны эх үүсвэрийн цэгээс ус ашиглагч уул уурхайн компани, сумдын ундны худаг, ус түгээх цэгүүдийг хамруулан 30 объектод бүс тогтоосон байдалд хяналт шалгалтыг 2024 оны 03 сарын 22 оос 2024 оны 06 дугаар сарын 13 ны өдрүүдэд хийхэд бүс тогтоох хуулийн хэрэгжилт 68 хувьтай байна. цэвэр усны үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй усны үйлдвэрүүд нь бүс тогтоох ажлыг хийж гүйцэтгээгүй | 2024.03.01 2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөрчилд зөрчил арилгах зөвлөмж зөвлөгөөг өгч ажиллаа. 2024 оны 04 дүгээр сарын 19 өдөр аймгийн ИТХ-ын 04 тогтоолоор аймгийн нутаг дэвсгэрт хамаарах усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалт, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн талбайн хэмжээг хот суурин газрын төвлөрсөн бус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоолгож хууль зүйн яаманд бүртгүүлсэн. Нийт газар нутгийн хэмжээ 8235711.518 га газартай үүнээс усан сан бүхий газар нь 4288006.77 га, усан сан бүхий газрын 3.41%-д онцгой хамгаалалтын бүс 1.79%-д энгийн хамгаалалтын бүсийг тогтоосон байна. | | |
| 4 | Ан агнах, барих, худалдах, худалдан авах, тээвэрлэх үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 30 | Ан амьтныг хамгаалах чиглэлээр гаргасан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд 19 иргэн хяналт шалгалтад хамрагдаж 7 иргэнд зөрчлийн тухай хуулийн дагуу 1.3 сая төгрөгөөр торгож, нөхөн төлбөрт 29.6 сая төгрөг оногдуулж ан амьтны түүхий эд зүйлийг хурааж орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн аймгийн хэмжээнд идлэг шонхор шувуу барих отгуудад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 5 суманд 27 идлэг шонхорын гэрээг байгуулан 28 шонхор шуувууны төлбөр болох | 2024.04.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 584.6 сая төгрөгийн төлбөрийг сумын байгалийн нөөц ашигласны төлбөрийн дансанд төвлөрүүлсэн. Улаанбаатар Баруун-Урт чиглэлийн пост болон сумдруу орж гарах 4 замын гарцанаар орж гарч буй 95 авто машинд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан. байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 15,0 сая төгрөгийг гаргаж "Авралын эрэл" ХХК-аар тарваганы байршил бүхий газар тооллого судалгааг 9 дүгээр сард хийж гүйцэтгсэн. Аймгийн хэмжээнд тооллого судалгаагаар нийт 2733 орчим тарвагатай болох нь тогтоогдсон | | |
| 5 | Химийн хорт болон аюултай бодис, аюултай хог хаягдлыг хадгалах, ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 15 | Химийн бодис ашиглах үйл ажиллагаа эрхлэгч 6 ААНБ, аюултай хог хаягдал хадгалах 7 ААНБ-д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд 257 нэр төрлийн 56.2 тн, 2236 л, 9211 кг химийн бодис байна. 6 ААНБ-д 20 сая төгрөгийн торгууль оногдуулсан.<br>Хугацаа дууссан химийн бодисыг тусгай сав агуулахад хадгалж лацадсан. | 2024.04.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |
| 6 | Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын ариун цэврийн байгууламж, хөрсний бохирдлын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 30 | Хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллах чиглэл бүхий БОГ-ийн 101 тоот албан бичгийг, эко жорлон үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл танилцуулгатай хүргэжажи лласан. Аймгийн хэмжээнд Түвшинширээ, Уулбаян, | 2024.04.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Баяндэлгэр, Мөнххаан суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЕБС, СӨБ- ийн. био нойл хийгдэж 2 тэрбум орчим төгрөг зарцуулагдсан байна. Халзан суманд-2 Түмэнцогт - 1, Түвшинширээ-2, Сүхбаатар - 7 Баруун-Урт -112, Эрдэнэцагаан -9 , Дарьганга -29, эко ариун цэврийн байгууламжийг байгуулсан байна. Аймгийн төвийн 4,6 дугаар багийн нийт 542 өрхийн нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийг Баруун-Урт сумын ЗДТГ-аар хийж гүйцэтгэсэн. 30 ААН-д хяналт шалгалтыг гүйцэтгэхэд стандартын шаардлага хангасан нүхэн жорлон байгуулаагүй 9 аж ахуйн нэгж байна. Хөрсний бохирдлыг арилгаж нүхэн жорлон байгуулах стандартыг хангаж ажиллах 3 заалт бүхий хугацаатай 4 албан шаардлага хүргүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулж байна. албан шаардлагын биелэлт 62%, хөрсний бохирдол үүсгэж нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдал асгасан 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 60.0 мянган төгрөгийн торгууль, 2 ААН-д 600.0 төгрөгөөр тус тус торгож шийдвэрлэсэн. Зөрчлийг 100% арилгасан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Авто замын өргөтгөл, шинээр барих, геологи, уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийсэн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 30 | Геологи уул уурхай, авто замын өргөтгөлийн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх удирдамжийн хүрээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Цайрт минерал ХХК, Монголжүюаньли ХХК, Говьмастер ХХК, Эм эл цахиурт овоо ХХК, Хунт өгөөж ХХК, Каскейд майнинг ХХК, Кинзроуд ХХК, Бадмаараг хаш ХХК, Эрээн толгой ХХК, Дорнын чулуулаг ХХК-д нь нүүрс, вольфрам олборлох зэргээр улс ашиглаж байгаад орхисон хуучин уул уурхайн ашиглалтын талбайн 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгсөн байна. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх ТЭЗҮ- г зардлыг Ланд овнер ХХК-аар Халзан сумын Хар худаг, Түвшинширээ сумын Бумбат, Мөнххаан сумын Хөх өндөр зэрэг газруудад нөхөн сэргээлтийн зардлыг тооцуулахад нийт 1.6 тэрбум санхүүжилт шаардлагатай гэсэн ТЭЗҮ, зураг төсөв гарсан. | 2024.04.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |
| 8 | Ой, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, худалдаалах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 30 | Баруун-Уртаас Улаанбаатар чиглэлийн авто замын шалган нэвтрүүлэх постоор орж гарч буй том оврын тээврийн хэрэгсэлд 2024 оны 02 сараас 2024 оны 05 сарын хооронд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 10 жолоочид, хууль бусаар огтолсон гарал үүслийн бичиггүй мод, модон материалыг тээвэрлэхгүй, худалдаж авахгүй байх зөвлөгөө зөвлөмжийг хүргэж | 2024.04.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллаа. Хяналт шалгалтын постоор зөрчил илрээгүй. | | |
| 9 | Агаар бохирдуулагч эх үүсвэр бүхий объектуудад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 30 | Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмыг боловсруулж БОУАӨ-ийн яаманд хүргүүлж хянуулж яамнаас журамд оруулах нэмэлт санал Аймгийн засаг даргад ирсэн. Тус саналыг дэмжиж БОУАӨЯ-ны сайдад албан бичгээр хүргүүлж журмыг батлах хамтарсан тушаал захирамжийн төслийг баталгаажуулж яаманд хүргүүлсэн тус онд багтаж батлагдахаар шийдвэрлэгдсэн. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн Сумдад засаг даргын захирамжийн ажлын хэсэг тооллогын ажлыг явуулж (www. envpol.mne.gov.mn) орчны бохирдлын эх үүсвэрийн хаягдлын тооллогын мэдээллийн санд эх үүсвэрийн хүчин чадлаар нь тоон мэдээлэл гаргаж нийт мэдээг мэдээллийн санд оруулсан. Аймгийн төвийн дулааны цахилгаан станц, усан болон уурын халаалтын зуух, уул уурхайн компанийн ашиглаж байгаа уурын зуух, сумдын томоохон эх үүсвэрүүдэд сумдын БОХУБ нартай хамтарч 30 эх үүсвэрт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд үнс баригч болон үнс хадгалах бункергүй агаар болон хөрс бохирдуулах эрсдэл 40 %-иас дээш буюу дунд эрсдэлтэй байна. хуулийн хэрэгжилт | 2024.04.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 76 хувьтай байна. уурын зуухны яндand шинжилгээ хийх сорьцын цэгийг 80% нь байгуулсан байна. | | |
| 10 | Байгалийн нөөц ашиглан төсөл хэрэгжүүлэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах үүргийн хэрэгжилтийн байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрадсан объектын тоо | 0 | 30 | Байгалийн нөөц ашиглалтын байдалд 34 ААНБ-д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 28 ААНБ-д 97 заалттай албан шаардлага хүргүүлж, албан шаардлага 82 хувийн биелэлттэй байна. 5 ААНБ-д 2.5 сая төгрөгийн торгууль оногдуулсан. | 2024.04.01<br>2024.12.01 | 100% |
| | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/ | 0 | 80 | | | |
| 11 | Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийг хяналт шалгалт хийх | Албан шаардлагын биелэлт /тоо, хувь/ | 0 | 30 | Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн обектийн 30 хувьд хийхээр төлөвлөж ажилласан. 10 аж ахуйн нэгжид гүйцэтглийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Нийт зөрчил арилалтын хувь 94% -тай, хууль сахин мөрдөлтийн хувь 50.25 буюу өмнөх шалгалтаас 2.85 хувиар өссөн | 2024.07.01<br>2024.12.01 | 0% |
| | | Зөрчил арилгалт /хувь/ | 0 | 80 | | | |
| 12 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | Өргөдөл гомдлын тоо /хувь/ | 0 | 3 | 2024 оны 01 сараас 2024 оны 11 сарын хугацаанд өргөдөл гомдлоор бүртгэгдсэн 17 гомдол мэдээллийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж 1 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 5 иргэнд 410.000 мянган төгрөгийн торгууль, 10 ААНБ-д 12.100.000 сая төгрөгний торгууль, 159978 төгрөгний нөхөн төлбөр тус тус оногдуулан шийдвэрлэсэн. | 2024.01.01<br>2024.12.01 | 100% |
| | | Шийдвэрэлэлт /хувь/ | 0 | 100 | | | |
| **Зорилт 3. " Хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч дээд шатны байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах, үүрэг даалгаварын хэрэгжилтийг үнэлж дүгнэх"** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчин аялал жуулчлалын яамны салбарын хяналтын газарт сар бүр тоон болон бичмэл тайлан хүргүүлэх | Хугацаандаа хүргүүлсэн тайлангийн тоо | 1 | 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбарын хяналтын газарт сар бүрийн 25-ны дотор батлагдсан загварын дагуу тоон болон бичмэл тайланг улсын ахлах байцаагч нарт хүргүүлэн ажиллаа. Нийт 22 тайлан мэдээг илгээсэн. | 2024.01.01 2024.12.01 | 100% |
| 2 | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг шийдвэрлэж прокурорыг хяналтад хүргүүлэх | Хянуулсан материалын тоо Зөрчлийн материалын шийдвэрлэлтийн хувь | 32 | 9 | 2024 онд 17 гомдол мэдээллийг бүртгэж Харьяаллын дагуу 1 гомдлыг шилжүүлж, 1 зөрчлийн хэрэг, 15 хялбаршуулсан журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж прокурорын хяналтад хүргүүлсэн байна. | 2024.04.01 2024.12.01 | 100% |
| 3 | Авлига, ашиг сонирхлын зөрчилөөс ангид байх | Авилга ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй | Тийм | - | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд нь 2024 оны 01 сарын 25-аас 02 сарын 14 ны хооронд meduuleg.iaac.mn web хуудсаар илгээж баталгаажуулсан. | 2024.01.20 2024.02.15 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Монгол бичгийн анхан болон дунд шатны цахим сургалтад хамрагдах | Сертификатын тоо | - | 1 | Удирдлагын академийн 40 цагийн цахим сургалтад амжилттай суралцаж үнэмлэх авсан. | 2024.01.01 2024.06.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Хүмүүн бичиг сонин захиалж унших | Захиалсан сонины тоо | - | 12 | Хүмүүн бичиг сонины 1, 2 дугаар улирлын захиалгыг хийж 12 дугаарыг авч уншин судалж байна. | 2024.01.0 12024.12. 01 | 100% |
| 3 | www.erp-mongolia.mn төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг хэрэглэж хэвших | Төлөвлөсөн албан бичгийн тоо | - | 3 | www.erp-mongolia.mn төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг хэрэглэж хэвших ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилд 5 бичиг төлөвлөн боловсруулж, 5 бичиг хүлээж авч шийдвэрлэсэн байна. | 2024.01.0 1 2024.12.0 1 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Байгаль орчны хяналтын улсын байцаагч ....[signature]...... / Ш.Шинэчимэг/ 2024.12.10

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*